

ДОРНОД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ
ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ АСУУДЛУУДЫН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022.01.31

Хэрлэн сум

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны 1 дүгээр сард 39 холбогдогчтой, 139.9 төгрөгийн хохиролтой, 61 гэмт хэрэг бүртгэгдэж, 3 хэргээр буюу 4.7 хувиар урьд оны мөн үеэс буурчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 20.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 34 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 9 буюу 87.5 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 8 буюу 30.8 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 46.8 төгрөг буюу 33.4 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн гаралт:-Хэрлэн сумын 1,3, 5, 7, 9, 10-р багууд Баян-Уул, Цагаан-Овоо, Сэргэлэн, Чойбалсан, Матад, Хөлөнбуйр, сумдуудад буурч
- Хэрлэн сумын 2,4,6,8,-р багууд Баянтүмэн, сумдуудад өсч, Гурванзагал, Булган, ,
Хэрлэн сумын 11-р баг ижил түвшинд, Чулуунхороот, Дашбалбар, Халхгол сумдад бүртгэгдээгүй байна.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргүүд тус бүр 1 бүртгэгдэж 100 хувь, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 31 бүртгэгдэж 6 буюу 24 хувь, залилах гэмт хэрэг 9 бүртгэгдэж 2 буюу 28.6 хувь, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 100 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 5 буюу 5 дахин хувиар тус тус өсөж,

Хөрөнгө завших, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд ижил түвшинд тус тус байна.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, дээрэмдэх, гээгдэл эд зүйл, алдуул мал завших, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, авлигын эсрэг, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг,цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь 4 буюу 18.1 хувиар буурсан ба үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 4 бүртгэгдэж 2 буюу 100 хувиар өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 3 бүртгэгдэж 5 буюу 62.5 хувиар буурчээ.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 23 бүртгэгдэж 22 буюу 22 дахин, хүүхэд оролцсон гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувиар тус тус өсөж,

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 4 бүртгэгдэж 5 буюу 55.6 хувь, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 2 хүн холбогдсон нь 6 буюу 75 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 буюу 50 хувиар тус тус буурч,

Галт зэвсгээр үйлдэгдсэн, гадаадын иргэн оролцсон гэмт хэргүүд тус тус бүртгэгдээгүй байна.

Үйлдэгдсэн газраар: - Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 4 бүртгэгдэж 4 буюу 4 дахин, байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 100 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 7 буюу 77.8 хувиар тус тус өссөн байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 19 бүртгэгдэж 11 буюу 36.7 хувь, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 1 буюу 14.2 хувь, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 33.3 хувь, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 4 бүртгэгдэж 2 буюу 33.3 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 буюу 20 хувиар тус тус буурчээ.

Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь: 22-06 цагийн хооронд 22 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 36%, 06-14 цагийн хооронд 14 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 22.9%, 14-19 цагийн хооронд 20 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 32.7%, 19-22 цагийн хооронд 5 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 8.1%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 12 буюу 19.6 хувь нь Баасан гарагт, 10 буюу 16.3% Даваа гарагт, 11 буюу 18% нь Мягмар, 6 буюу 9.8 хувь нь Пүрэв гаригт, Лхагва гарагт 8 буюу 13.1%, 9 буюу 14.7% Бямба гарагт, 5 буюу 8.1% нь Ням гарагт тус тус үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг байршлаар нь: Хэрлэн сумын 9, 10, 11 дүгээр багууд, Матад, Чойбалсан, Баянтүмэн, Булган, Сэргэлэн, Баяндун, Баян-Уул сумдад тус бүр 1 буюу 4.3 хувь, Хэрлэн сумын 1, 2, 7 дугаар багууд, Гурванзагал сумдад тус бүр 2 буюу 8.6 хувь, Хэрлэн сумын 6-р багт 5 буюу 21.7 хувиар тус тус бүртгэгдсэн байна.

Согтуугаар бүртгэгдсэн гэмт хэргийн 20 буюу 86.9 хувь нь хүний эрүүл халдашгүй байдлын эсрэг, 1 буюу 4.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүнийг алах, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргүүд эзлэж байна.

ХОЁР. ЗӨРЧИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны 1 дүгээр сард 1529 зөрчил илрүүлсэн нь 824 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 1.1 дахин хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 1394 иргэнийг 59990.0 төгрөгөөр торгож, 58 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч шийдвэрлэжээ. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 217 иргэнийг эрүүлжүүлсэн нь 69 буюу 24.1 %-иар буурсан байна.

Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:

- | | |
|---------------------------------|--------------------------------|
| - Ням гарагт 201 буюу 13.1 %, | - Лхагва гарагт 239 буюу 14.7% |
| - Баасан гарагт 198 буюу 12.9%, | - Даваа гарагт 245 буюу 16%, |
| - Пүрэв гарагт 232 буюу 15.1 %, | - Бямба гарагт 177 буюу 11.5%, |
| - Мягмар гарагт 237 буюу 15.5%, | |
| - 13-18 цагт 1012 буюу 66.1%, | - 19-24 цагт 303 буюу 19.8%, |
| - 06-12 цагт 192 буюу 12.5 % | - 01-05 цагт 22 буюу 4.1%. |

Үйлдэгдсэн онцлогоор нь:

- | | |
|-----------------------------------|-----------------------------|
| • Согтуугаар үйлдэгдсэн | 80 буюу 5.2% |
| • Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 11 буюу 0.7% |
| • Эмэгтэй хүн оролцсон | 0 буюу 0% |
| • Харьяалалгүй иргэн | 0 буюу 0% |
| • Урьд ял шийтгэгдсэн | 0 буюу 0% |
| • Хүүхэд оролцсон | 0 буюу бүртгэгдээгүй байна. |

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган 217 иргэн саатуулагджээ. Үүний 20 буюу 9.2% нь эмэгтэй хүн эзлэж байна.

нийгмийн байдлаар нь:

- | | |
|-----------------------------|-----------------------------|
| • Ажилгүй | 208 буюу 95.8% |
| • Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 1 буюу 1.3% |
| • Бусад | 2 буюу 0.5 %-г эзэлж байна. |

Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:

- | | |
|---|-----------------------|
| • Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан | 290 буюу 81.2% |
| • Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон | 23 буюу 6.4 % |
| • Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон | 15 буюу 4.2% |
| • Хаана байгаагаар, очих газраа мэдэхгүй болсон | 26 буюу 7.2 % |
| • Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй | 3 буюу 0.8% |

Эрүүлжүүлэгдсэн газраар нь:

- | | |
|---------------------------------|---------------------------------|
| • Гэр, орон сууцнаас | 174 буюу 80.1% |
| • Гудамж талбайгаас | 23 буюу 10.4% |
| • Байгууллага, аж ахуйн нэгжээс | 6 буюу 2.7% |
| • Баар, цэнгээний газраас | 4 буюу 1.8% |
| • Зочид буудлаас | 7 буюу 3.2% |
| • Бусад | 3 буюу 1.3 % нь эрүүлжүүлэгджээ |

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн 37.7%, зөрчлийн 5.2%-ийг согтуугаар, гэмт хэргийн 1.6 %, зөрчлийн 0.7%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

2. Нийт гэмт хэргийн 32.7 хувь нь 14-19 цагт, зөрчлийн 66.1% нь 13-18 цагт тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн 27.3% нь Бямба, зөрчлийн 19.5% нь тус бүр Баасан гаригт үйлдэгджээ.

3. Гэмт хэргийн 31.1%, зөрчлийн 5.2%, саатуулсан хүний 81.5% нь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 86.9 % нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүлжүүлэгдсэн хүний 81.5%-ийг бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байгаа ба, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 0.4 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

5 Хүнийг алах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хууль бусаар мод бэлтгэх, бусад төрлийн гэмт хэргүүд тус тус өссөн байна.

ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Аймгийн хэмжээнд залилах гэмт хэрэг 9 бүртгэгдэж 2 буюу 28.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг цаашид өсөх хандлагатай байгаа тул урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албан тушаалтан нар мөрдөн байцаах албатай хамтарч нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулах.
2. Байгууллага аж ахуй нэгж, олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэргүүд тус тус өссөн байгаад онцгой анхаарч байгууллага аж ахуй нэгжүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг хүргэж, албан мэдэгдлийг хүргүүлэн үр дүнг тооцох, мөн баг, сум хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар багийн хэмжээнд нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулах.
3. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад 100 хувь өссөн байна. Иймд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизээр энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, зурагт хуудас, шторк зэргийг олон нийтийн газруудад байршуулах.
4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 22 дахин өссөн байгаа тул баг, сум хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

Та бүхний ажилд амжилт хүсье.

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**